



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/361

Булган сум

**“Эрүүл залуучууд-ирээдүйн эзэд” залуучуудын  
сургалт зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.2, 21.1.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Залуусын хөгжил” дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эрүүл залуучууд-ирээдүйн эзэд” залуучуудын сургалтыг зохион байгуулсугай.

2. Залуучуудын сургалтыг зохион байгуулах үйл ажиллагаанд шаардагдах 10,280,000 (арван сая хоёр зуун наян мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Залуусын хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэбилэг)-т зөвшөөрсүгэй.

3. “Эрүүл залуучууд-ирээдүйн эзэд” сургалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, сум бүрийн оролцоог ханган хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (О.Ундрах)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА


Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010492

Sugar Ажил 2026 өдөр бүр Doc/2026/Захирамж

Аймгийн Засаг даргын 2026 оны  
05 дугаар сарын 11-ны/ний өдрийн  
А/361 дугаар захирамжийн хавсралт



“ЭРҮҮЛ ЗАЛУУЧУУД-ИРЭЭДҮЙН ЭЗЭД”  
СУРГАЛТЫН ТӨСӨВ

| д/д                       | Хугацаа                                       | Хүний тоо | Давтамж | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ  | Тайлбар      |
|---------------------------|---|-----------|---------|----------------|-----------|--------------|
| 1                         | 2   | 3         | 4       | 5              | 6         | 7            |
| <b>Хоолны зардал</b>      |   |           |         |                |           |              |
| 1                         | Цайны завсарлага                              | 205       | 1       | 4,000          | 820,000   | Dream lounge |
| 2                         | Өдрийн хоол                                   | 205       | 1       | 20,000         | 4,100,000 |              |
| 3                         | Оройн хоол                                    | 205       | 1       | 20,000         | 4,100,000 |              |
| Дүн                       |   |           |         |                | 9,020,000 |              |
| <b>Оролцогчдын буудал</b> |   |           |         |                |           |              |
| 4                         | Мод тарих хэрэглэгдэхүүн-<br>(бээлий, шуудай) | 200       | 1       | 3,800          | 760,000   | -            |
| 5                         | Театрын заалны түрээс                         | 1         | 1       | 500,000        | 500,000   | -            |
| Дүн                       |   |           |         |                | 1,260,000 |              |
| <b>Нийт – 10,280,000</b>  |   |           |         |                |           |              |

--o00o--